

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: **БӨА-2022/102/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|--|
| <p>Цахим хуудас: www.audit.mn Өлгий хот 2022 он</p> | <p>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn Аудитын менежер: Х.Женисбек Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn Аудитор: Ж.Назгүл Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn</p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 7 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан..... | 7 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 9 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 11 |
| 3. Аудитын тайлан..... | 12 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 12 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 12 |
| 3.4 Материаллаг байдал | 13 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 13 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 14 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 15 |
| 3.8 Аудитын гол асуудал | 15 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... | 15 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт..... | 16 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал..... | 16 |
| 4. Аудитын илрүүлэлт | 16 |
| 4.1 Залруулсан алдаа..... | 16 |
| 4.2 Төлбөрийн акт..... | 16 |
| Тогтоосон төлбөрийн акт байхгүй | 16 |
| 4.3 Албан шаардлага | 16 |
| 4.4 Зөвлөмж | 17 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

**УЛААНХУС СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ЭРХЛЭГЧ З.МУХТАР
ТАНАА**

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒᠑ № ᠒᠑7
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|-------------|--------------------------------------|------------------------------|--------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>80,044,828.96</u> | <u>126,455,950.95</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 1,130,053.73 | 1,138,040.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 1,130,053.73 | 1,138,040.00 |
| 3121 | Төгрөг | 1,130,053.73 | 1,138,040.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 1,138,040.00 |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | 1,130,053.73 | |
| 33 | АВЛАГА | 5,736,729.50 | 46,390,500.00 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | 46,390,500.00 |
| 335 | Бусад авлага | 5,736,729.50 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 5,736,729.50 | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 73,178,045.73 | 78,927,410.95 |
| 351 | Түүхий эд материал | 23,817,592.59 | 19,684,949.16 |
| 35130 | Эм боох материал | 23,817,592.59 | 19,684,949.16 |
| 354 | Хангамжийн материал | 49,360,453.14 | 59,242,461.79 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 5,200.00 | 159,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 41,100,798.75 | 45,595,165.75 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 274,000.00 | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 567,971.50 | 206,799.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 67,746.00 | 67,746.00 |
| 35460 | Хүнсний материал | 7,284,736.89 | 13,152,851.04 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 60,000.00 | 60,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>572,144,832.96</u> | <u>995,516,012.55</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 572,144,832.96 | 995,516,012.55 |
| 392 | Биет хөрөнгө | 556,944,832.96 | 980,316,012.55 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 479,346,382.40 | 811,936,966.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (71,060,125.92) | (107,849,752.57) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 144,027,612.00 | 123,082,132.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (42,752,409.48) | (48,915,889.40) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 57,110,229.03 | 199,235,949.86 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (24,478,749.48) | (42,080,086.32) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 15,784,100.00 | 49,699,300.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (5,683,316.68) | (9,097,051.83) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,200,000.00 | 5,200,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (548,888.91) | (895,555.59) |
| 393 | Биет бус хөрөнгө | 15,200,000.00 | 15,200,000.00 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | 550,000.00 | 550,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 15,200,000.00 | 15,200,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>652,189,661.92</u> | <u>1,121,971,963.50</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>9,577,544.78</u> | <u>10,633,750.50</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 9,577,544.78 | 10,633,750.50 |
| 413 | Өглөг | 9,577,544.78 | 10,633,750.50 |
| 4136 | Бусад өглөг | 9,577,544.78 | 10,633,750.50 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 9,577,544.78 | 10,633,750.50 |

| | | | |
|------------|---|------------------------------|--------------------------------|
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>642,612,117.14</u> | <u>1,111,338,213.00</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 642,612,117.14 | 1,111,338,213.00 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 376,160,585.01 | 376,160,585.01 |
| 51101 | Өмч: - төрийн | 376,160,585.01 | 376,160,585.01 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (57,533,022.66) | 411,193,073.20 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (57,533,022.66) | (57,533,022.66) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | 468,726,095.86 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 323,984,554.79 | 323,984,554.79 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>652,189,661.92</u> | <u>1,121,971,963.50</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 1,014,217,948.73 | 1,899,204,269.83 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 71,492,877.73 | 35,734,648.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 71,492,877.73 | 35,734,648.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 71,492,877.73 | 35,734,648.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 53.73 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 71,492,824.00 | 35,734,648.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 942,725,071.00 | 1,863,469,621.83 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 771,381,000.00 | 1,538,723,804.83 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | | 603,384,604.83 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 771,381,000.00 | 935,339,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 75,671,805.00 | 195,129,782.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,671,805.00 | 195,129,782.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 27,155,200.00 | 22,249,195.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 27,155,200.00 | 22,249,195.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 68,517,066.00 | 107,366,840.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 39,456.00 | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 68,477,610.00 | 107,366,840.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 992,393,452.81 | 1,320,149,574.73 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 992,393,452.81 | 1,320,149,574.73 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 982,329,470.81 | 1,248,949,574.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 613,381,952.00 | 817,069,050.73 |
| 210101 | Үндсэн цалин | 408,086,552.00 | 498,452,450.73 |
| 210102 | Нэмэгдэл | 166,496,400.00 | 200,446,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 12,599,900.00 |
| 210104 | Урамшуулал | 38,799,000.00 | 63,745,500.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 41,824,400.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 130,443,700.00 | 100,911,141.00 |

| | | | |
|-------------|---|----------------|----------------|
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,076,600.00 | 71,389,559.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,091,800.00 | 7,560,750.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,873,400.00 | 5,601,932.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,218,400.00 | 1,487,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,183,500.00 | 14,871,700.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 26,156,955.50 | 25,944,788.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,847,623.00 | 3,483,816.00 |
| 210302 | Түлш, халаалт | 23,309,332.50 | 22,460,972.50 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 53,869,671.00 | 81,223,779.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,642,250.00 | 4,024,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 44,476,590.00 | 66,133,480.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,476,950.00 | 2,311,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,273,881.00 | 5,400,249.20 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 3,353,450.00 |
| 2105 | Нормативт зардал | 80,651,600.14 | 130,592,402.30 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 70,189,138.45 | 118,679,463.65 |
| 210502 | Хоол, хүнс | 7,882,961.69 | 11,912,938.65 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,579,500.00 | |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,501,000.00 | 6,165,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 5,195,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,501,000.00 | 970,500.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 336,000.00 | 1,971,662.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 336,000.00 | 1,971,662.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 568,400.00 | 876,285.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 244,800.00 | 506,135.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 53,400.00 | 133,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 124,720.00 | 113,720.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 21,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | 101,480.00 | 101,480.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 73,420,192.17 | 84,194,966.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,869,293.00 | 5,943,240.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 63,550,899.17 | 78,251,726.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,063,982.00 | 71,200,000.00 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 39,456.00 | 71,200,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 39,456.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 71,200,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,835,670.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,835,670.00 | |

| | | | |
|-------------|---|-----------------------------|------------------------------|
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,139,456.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,139,456.00 | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 49,400.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 49,400.00 | |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>21,824,495.92</u> | <u>579,054,695.10</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 11,819,444.56 | 110,328,599.24 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 11,819,444.56 | 110,328,599.24 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (11,819,444.56) | (110,328,599.24) |
| 5 | НИИТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>10,005,051.36</u> | <u>468,726,095.86</u> |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|-------|--|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 376,160,585.01 | 323,984,554.79 | (57,533,022.66) | | 642,612,117.14 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 376,160,585.01 | 323,984,554.79 | (57,533,022.66) | - | 642,612,117.14 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | - |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 376,160,585.01 | 323,984,554.79 | (57,533,022.66) | - | 642,612,117.14 |
| D01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 376,160,585.01 | 323,984,554.79 | (57,533,022.66) | - | 642,612,117.14 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 376,160,585.01 | 323,984,554.79 | (57,533,022.66) | - | 642,612,117.14 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 468,726,095.86 | | 468,726,095.86 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 376,160,585.01 | 323,984,554.79 | 411,193,073.20 | - | 1,111,338,213.00 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------------|--------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>942,725,124.73</u> | <u>1,213,694,517.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 53.73 | - |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 53.73 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 53.73 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 53.73 | |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 942,725,071.00 | 1,213,694,517.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 771,381,000.00 | 935,339,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 771,381,000.00 | 935,339,200.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 75,671,805.00 | 195,129,782.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 75,671,805.00 | 195,129,782.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 27,155,200.00 | 22,249,195.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 27,155,200.00 | 22,249,195.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 68,517,066.00 | 60,976,340.00 |

| | | | |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 68,477,610.00 | 60,976,340.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 942,725,071.00 | 1,205,119,630.73 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 942,725,071.00 | 1,205,119,630.73 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 932,661,089.00 | 1,133,919,630.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 603,066,087.00 | 817,069,050.73 |
| 210101 | Үндсэн цалин | 397,770,687.00 | 498,452,450.73 |
| 210102 | Нэмэгдэл | 166,496,400.00 | 200,446,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | 12,599,900.00 |
| 210104 | Урамшуулал | 38,799,000.00 | 63,745,500.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | 41,824,400.00 |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | | |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 130,443,700.00 | 100,911,141.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 106,076,600.00 | 71,389,559.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,091,800.00 | 7,560,750.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,873,400.00 | 5,601,932.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,218,400.00 | 1,487,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,183,500.00 | 14,871,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,430,244.00 | 21,465,195.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,501,844.00 | 3,829,595.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,928,400.00 | 17,635,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 56,995,470.00 | 70,601,950.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,537,700.00 | 4,264,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,922,400.00 | 57,223,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,476,950.00 | 2,311,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,058,420.00 | 3,807,050.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 2,994,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 88,317,795.00 | 105,422,207.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 71,027,239.00 | 84,275,775.00 |
| 210502 | Хоол, хүнс | 14,858,556.00 | 18,131,732.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,432,000.00 | 3,014,700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 3,005,500.00 | 5,730,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,420,000.00 | 4,946,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,585,500.00 | 784,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 336,000.00 | 1,971,662.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 336,000.00 | 1,971,662.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 18,600,000.00 | 876,285.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 18,031,600.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 244,800.00 | 506,135.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 53,400.00 | 133,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 124,720.00 | 113,720.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 21,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 101,480.00 | 101,480.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,466,293.00 | 9,872,140.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,466,293.00 | 9,872,140.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 10,063,982.00 | 71,200,000.00 |

| | | | |
|-------------|---|--------------|-----------------------|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 39,456.00 | 71,200,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 39,456.00 | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 71,200,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 7,835,670.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 7,835,670.00 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,139,456.00 | - |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,139,456.00 | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 49,400.00 | - |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 49,400.00 | |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 53.73 | 8,574,886.27 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | - | 8,566,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | - | 8,566,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 8,566,900.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | | 8,566,900.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | (8,566,900.00) |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 53.73 | 7,986.27 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 1,130,053.73 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 53.73 | 1,138,040.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|------------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 1,130,053.73 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,024,411,700.00 | 1,018,556,748.73 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,024,411,700.00 | 1,018,556,748.73 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,024,411,700.00 | 1,018,556,748.73 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 743,586,300.00 | 744,716,353.73 |
| 210101 | Үндсэн цалин | 424,969,700.00 | 426,099,753.73 |
| 210102 | Нэмэгдэл | 200,446,800.00 | 200,446,800.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 12,599,900.00 | 12,599,900.00 |
| 210104 | Урамшуулал | 63,745,500.00 | 63,745,500.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 41,824,400.00 | 41,824,400.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 100,384,100.00 | 94,236,213.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,640,700.00 | 65,366,681.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,435,800.00 | 6,908,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,948,700.00 | 5,601,932.00 |

| | | | |
|-------------|---|------------------|------------------|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,487,200.00 | 1,487,200.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,871,700.00 | 14,871,700.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 21,465,200.00 | 21,465,195.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,329,300.00 | 3,829,595.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17,135,900.00 | 17,635,600.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 66,404,300.00 | 66,392,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,624,800.00 | 3,624,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 54,793,600.00 | 54,793,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,667,400.00 | 1,666,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 3,818,500.00 | 3,807,050.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,500,000.00 | 2,499,800.00 |
| 2105 | Нормативт зардал | 74,745,900.00 | 74,732,632.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 52,986,200.00 | 52,986,200.00 |
| 210502 | Хоол, хүнс | 18,744,400.00 | 18,731,732.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,015,300.00 | 3,014,700.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,161,500.00 | 3,858,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,074,000.00 | 3,074,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,087,500.00 | 784,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,030,000.00 | 826,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,030,000.00 | 826,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,176,700.00 | 876,285.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | 506,135.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 164,000.00 | 133,950.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 195,900.00 | 113,720.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 66,000.00 | 21,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | |
| 210807 | Газрын төлбөр | 150,800.00 | 101,480.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,457,700.00 | 11,454,020.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,457,700.00 | 11,454,020.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 1,024,411,700.00 | 1,018,564,735.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 935,339,200.00 | 935,339,200.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 935,339,200.00 | 935,339,200.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 22,552,700.00 | 22,249,195.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 22,552,700.00 | 22,249,195.00 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 66,519,800.00 | 60,976,340.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | | |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 66,519,800.00 | 60,976,340.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 1,130,053.73 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 1,138,040.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 50.00 | 55.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 2.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 40.00 | 39.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 9.00 | 9.00 |

| | | | |
|--------|----------------|--|------|
| 620004 | Гэрээт ажилтан | | 5.00 |
|--------|----------------|--|------|

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|-------------|--|----------------------|-----------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 75,671,805.00 | 195,129,782.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 75,671,805.00 | 195,129,782.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 75,671,805.00 | 123,929,782.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | - | 72,352,697.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 72,352,697.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,204,900.00 | 6,674,928.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,204,900.00 | 6,022,878.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 652,050.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 49,400.00 | 4,209,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 640,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 49,400.00 | 2,429,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | 645,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 495,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 27,417,505.00 | 31,289,575.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 27,417,505.00 | 31,289,575.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 2,299,580.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 2,299,580.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | 1,145,662.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 1,145,662.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 5,957,440.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 5,957,440.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | - | 71,200,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | - | 71,200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 71,200,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 195,129,782.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 195,129,782.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 195,129,782.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ны өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь үйлчлүүлэгчийн хэрэгцээнд тулгуурлан эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх замаар ирээдүйгээ бүтээнэ гэсэн зорилго дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба ажилладаг бөгөөд тайлант онд тус байгууллагад шалгалт хийсэн байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийн сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 991.2 сая төгрөгөөс 1 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 469.8 сая төгрөгөөр буюу 72 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|------------------|--------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 1,130.0 | 1,138.0 | 8.0 |
| Авлага | 5,736.7 | 46,390.5 | 40,653.8 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 73,178.0 | 78,927.4 | 5,749.4 |
| Үндсэн хөрөнгө | 572,144.8 | 995,516.0 | 423,371.2 |
| Нийт хөрөнгө | 652,189.7 | 1,121,971.9 | 469,782.3 |
| Өр төлбөр | 9,577.5 | 10,633.7 | 1,056.2 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 642,612.1 | 1,111,338.2 | 468,426.1 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 652,189.7 | 1,121,971.9 | 469,782.3 |

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 1.1 сая төгрөгийн үлдэгдэлгүй байгаа нь төрийн сан дахь үндсэн дансны үлдэгдэл байна.

Авлага данс тайлант оны эцэст 46.4 сая болж өмнөх оноос 40.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилтийн авлага нэмэгдсэнээс шалтгаалжээ. Оны эхний 5.7 сая төгрөгийн тээвэр шатахууны авлагыг барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 78.9 сая төгрөг болж 5.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд 189.2 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч, аймгийн Эрүүл мэндийн газраас 22.4 сая төгрөгийн, сумын Засаг даргын тамгын газраас ковид цар тахалтай холбоотой 11.8 сая төгрөгийн, Эргэлтийн эмийн сангийн орлогоос 1.5 сая төгрөгийн бараа материалыг үнэгүй авч, 219.2 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/19 дугаар тушаалаар байгуулсан жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комиссын хийсэн тооллогоор 1.0 сая төгрөгийн аж ахуйн материал, 6.8 сая төгрөгийн хүнсний материал дутагдсан бөгөөд үүнийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 995.5 сая төгрөг болж 423.4 сая төгрөгөөр өссөн байна. Төсвийн хөрөнгөөр 8.5 сая төгрөгийн хөрөнгийг худалдан авч, Эрүүл мэндийн

яамны хөрөнгө оруулалтаар 332.6 сая төгрөгийн сумын Эрүүл мэндийн төвийн барилгын өргөтгөл, Хөххөтөл багийн Их эмчийн салбарт 39.8 сая төгрөгийн автомашин, 173.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 30.1 сая төгрөгийн тавилгыг тус тус хүлээн авсан байна. Мөн аймгийн Эрүүл мэндийн газраас 18.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, 0.2 сая төгрөгийн тавилга, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 4.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Эргэлтийн эмийн сангийн хөрөнгөөр 1.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 120 дугаар тогтоолоор Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн дансанд бүртгэлтэй байгаа 63.4 сая төгрөгийн балансын үнэтэй тоног төхөөрөмжийг Булган, Дэлүүн, Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв болон аймгийн Нэгдсэн эмнэлгийн дансанд шилжүүлж, данс бүртгэлээс хассан байна.

Мөн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 89 дугаар тогтоолоор 60.8 сая төгрөгийн балансын дүнтэй 13.9 сая төгрөгийн элэгдэлтэй Land-76 автомашиныг Улаанхус сумын Засаг даргын тамгын газрын дансанд шилжүүлж, үндсэн хөрөнгөд 78.2 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Өглөг дансны үлдэгдэл 10.6 сая төгрөг болж өссөн нь 3.5 сая төгрөгийн тээвэр шатахууны, 7.1 сая төгрөгийн түлш халаалтын өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1111.3 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 468.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны анх батлагдсан төсөв 1024.4 сая төгрөг ба тодотголоор төсөвт өөрчлөлт ороогүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1024.4 сая төгрөгийн батлагдсан төсвөөр үйл ажиллагаа явуулж, гүйцэтгэлээр үйл ажиллагаандаа 1018.5 сая төгрөгийг зарцуулж, 5.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгээс 935.3 сая төгрөг, Орон нутгийн төсвөөс 22.2 сая төгрөгийн, Эрүүл мэндийн даатгалын сангаас 60.9 сая төгрөгийн санхүүжилт авсан байна.

Батлагдсан төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж судалж үзэхэд төвлөрүүлсэн хөрөнгө байхгүй, харин өглөгтэй гарсан байна.

Нийт төсвийн 73.1 хувийг цалин, 9.2 хувийг НДШ-ийн зардал, 2.1 хувийг тогтмол зардал, 6.5 хувийг хангамж бараа материалын зардал, 7.3 хувийг норматив зардал, 0.4 хувийг урсгал засварын зардал, 0.08 хувийг дотоод томилолтын зардал, 0.09 хувийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, 1.1 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт дансаар 195.1 сая төгрөгийн санхүүжилтийг Эрүүл мэндийн яамнаас хүлээн авч 72.3 сая төгрөгийг цалингийн зардалд, 6.7 сая төгрөгийг НДШ-д, 4.2 сая төгрөгийг хангамж, бараа материалын зардалд, 31.3 сая төгрөгийг нормативт зардалд, 2.3 сая төгрөгийг эд хогшил, урсгал засварын зардалд, 1.1 сая төгрөгийг томилолтын зардалд, 6.0 сая төгрөгийг бараа үйлчилгээний бусад зардалд, 71.2 сая төгрөгийг нэг удаагийн тэтгэмжийн зардалд тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайланд холбогдох бүх мэдээллийг толилуулж, тодруулсан байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

Эргэлтийн эмийн сангийн эм, эм боох материалын худалдан авалт, зарцуулалтыг данс бүртгэлд тусаагүй, эмийн эхний болон эцсийн үлдэгдэл тодорхой бус, эмийн бүртгэл тооцоо, санхүүгийн тайланд гаргалт зохих журмаар хийгдээгүй байна.

Эрүүл мэндийн төвийн Хөөхөтөл багийн их эмчийн салбарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2021 оны 5 дугаар сарын 15-ны хүртэл галчаар ажилласан иргэний цалинг салбарын эрхлэгч нарын маргаантай үйл ажиллагаанаас болж олгоогүй байна.

Галч нь аймаг дахь Сум дундын анхан шатны шүүхэд өргөдөлд гаргаж, шүүгчийн 130/ШШ2021/00572 дугаар захирамжаар 1.5 сая төгрөгийг тус Эрүүл мэндийн төвийн төсвөөс гаргах шийдвэр гарсан байна.

Эрүүл мэндийн төвийн эрхлэгч шүүхийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөөгүйн улмаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2021 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн “Төлбөр төлөгчийн банк дахь хадгаламжийн болон харилцах данс битүүмжлэх, хасалт хийх” тухай 06/451 дугаар тогтоолын дагуу Эргэлтийн эмийн сангийн арилжааны банк дах данснаас 1.6 сая төгрөгийг албадан суутган авсан байна.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд 2021 оны санхүүгийн тайланд үлэмж нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл гараагүй байна.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБООС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг

стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Улаанхус сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд нийт 1024.4 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 140 мэдээллийг хугацаандаа оруулж, 7 мэдээллийг хугацаа хоцроож оруулсан байна. Шилэн дансны хэрэгжилт 96 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, батлагдсан төсвийн зарцуулалт нь төсвийн тухай хууль тогтоомжийг холбогдох заалтуудад нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөрчил арилгуулах 90.5 сая төгрөгийн 1 зөвлөмж, 105.8 сая төгрөгийн 1 албан шаардлага өгөгдөж биелэлтийг Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгчийн 2021 оны 06 дугаар сарын 30 өдрийн 21 тоот албан бичгээр ирүүлжээ.

Давтан шалгаж үзэхэд гарсан зөрчлийг арилгаж оны эцэст хөрөнгийн тооллого хийж, зардал хооронд зөвшөөрөлгүй гүйлгэн зарцуулалтыг зогсоож ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарал хандуулах зүйл гараагүй. Тус төвийн ажилчдад олгосон илүү цагийн хөлсийг нарийвчлан шалгах боломжгүй байгаа тул гүйцэтгэлийн шалгалтаар шалгах шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 54.2 сая төгрөгийн зөрчил илэрч 7.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 46.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

4.2 Төлбөрийн акт

Тогтоосон төлбөрийн акт байхгүй

4.3 Албан шаардлага

Аудитаар 7.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Эрүүл мэндийн төвийн даргын 2021 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн А/19 дугаар тушаалаар байгуулсан жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийх комиссын хийсэн тооллогоор 1.0 сая төгрөгийн аж ахуйн материал, 6.8 сая төгрөгийн хүнсний материал дутсан байна. Тооллогын комисс дутсан бараа материалын талаар акт үйлдсэн бөгөөд санхүүгийн тайланд хүнсний материалын үдэгдлээр тайлагнаж ирүүлсэн байна. Тус Эрүүл мэндийн төвийн нярав нь 2021 оны 8 дугаар сард гэнэт нас барсан бөгөөд тооллогоор дутсан бараа материалыг хариуцах эзэнгүй болсон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 “үнэн зөв байх”, 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д “Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузал суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэсэн заалтыг зөрчсөн байна

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар албан шаардлага өгөв.

4.4 Зөвлөмж

Аудитаар 46.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөгдлөө.

1. Шилэн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст оны эцэст үүссэн 46.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн шийдвэрийн талаарх мэдээллийг байршуулаагүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаандаа бүрэн байршуулж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2021 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Улаанхус сумын Эрүүл мэндийн төв | 2 | 54.2 | | | | | 1 | 7.8 | 1 | 46.4 |